



VII/2021

Тархаасан: 2021 оны 9 дүгээр сарын 10



Гадаад худалдааны нөхцөлийн индекс 2021 оны 7 дугаар сард өмнөх оны мөн үеэс 16.5 хувиар өссөн байна

Гадаад худалдааны нөхцөлийн индекс (2015=100, туршилт тооцоогоор) 2021 оны 7 дугаар сард 154.2 болж, өмнөх оны мөн үеэс 16.5 хувь, өмнөх оны эцсээс 6.6, өмнөх сараас 1.1 хувиар тус тус өссөн байна.

Экспортын үнийн индекс (2015=100, туршилт тооцоогоор) 2021 оны 7 дугаар сард 161.7 болж, экспортын үнэ өмнөх оны мөн үеэс 34.7 хувь, өмнөх оны эцсээс 20.4, өмнөх сараас 2.7 хувиар тус тус өссөн байна.

Экспортын үнийн индекс өмнөх оны мөн үеэс 34.7 хувиар өсөхөд эрдэс бүтээгдэхүүний бүлгийн үнэ 48.9 хувиар (төмрийн хүдэр, зэсийн баяжмал, чулуун нүүрс, түүхий нефть) өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Импортын үнийн индекс (2015=100, туршилт тооцоогоор) 2021 оны 7 дугаар сард 104.9 болж, импортын үнэ өмнөх оны мөн үеэс 15.5 хувь, өмнөх оны эцсээс 13.0 хувь, өмнөх сараас 1.5 хувиар тус тус өссөн байна. Импортын үнийн индекс өмнөх оны мөн үеэс 15.5 хувиар өсөхөд эрдэс бүтээгдэхүүний бүлгийн үнэ 20.2 хувиар (нефть) өссөн нь голлон нөлөөлсөн байна.

ЗУРАГ 1. ГАДААД ХУДАЛДААНЫ НӨХЦӨЛИЙН ИНДЕКС¹ (2015=100), хувь



¹ Туршилт тооцоо

Ойлголт, тодорхойлолт

Монгол Улсын гадаад худалдааны нөхцөлийн индексийг экспортын үнийн ерөнхий индексийг импортын үнийн ерөнхий индексэд харьцуулж тооцно.

Экспортын үнийн индекс: Монгол Улсын экспортын голлох худалдааны түнш орнуудад нийлүүлж буй барааны үнийн нэгдсэн индексийг ойлгоно.

Импортын үнийн индекс: Монгол Улсын худалдааны түнш орнуудаас импортолж буй гол нэрийн барааны үнийн нэгдсэн индексийг ойлгоно.

Суурь үе: Индекс тооцоход хугацааны бусад үеийн үзүүлэлтэд харьцуулж тооцох хугацаа юм.



Эх үүсвэр: Гаалийн ерөнхий газар

Ангилал: Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2021 оны 10 дугаар сарын 15

Эдийн засгийн статистикийн газрын
дарга А.Дэмбэрэл
Утас : (976-11)-329272

Эдийн засгийн статистикийн газрын
статистикч Г.Мөнх-Оргил
Утас : (976-51)-261559



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212